



ЗЭВСГИЙН ХУДАЛДААНЫ ГЭРЭЭ БА ХОХИРОГЧДОД ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ ТӨРИЙН ҮҮРЭГ

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



ГАРЧИГ

ОЛОН УЛСЫН ХЭМ ХЭМЖЭЭ.....	5
ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ДАГУУ ХАМГААЛАГДСАН ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ.....	7
ХАВСРАЛТ	8
Хохирлыг арилгах нөхөн төлбөртэй холбоотой олон улсын эрх зүйн хэм хэмжээ	8
Хүний эрхийн бүс нутгийн конвенциуд	10
Олон улсын хүмүүнлэгийн эрх зүй	11
Гэмт хэргийн хохирогч	12
Нийлмэл гэмт хэрэг	13
Террорист үйл ажиллагааны хохирогч	14
Хүн худалдах гэмт хэргийн хохирогч.....	14
Зэвсгийн талаархи гэрээ хэлэлцээр	15

ОЛОН УЛСЫН ХЭМ ХЭМЖЭЭ¹

2006 онд Нобелийн энх тайвны шагналтнуудаар удирдуулсан бүх бүс нутгийн Төрийн бус байгууллага, тухайлан Эмнести Интернэшнл байгууллагаас олон улсын кампанит ажил явуулсны дараа ердийн зэвсгийн олон улсын шилжүүлэг, экспорт, импортод тохирох олон улсын нийтлэг жишиг, хамгийн боломжит үр дүнтэй арга хэрэгслийг бий болгох, “хатуу, тогтвортой” хэлэлцээр байгуулахыг гишүүн орнууддаа уриалсан НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 64/48 тоот тогтоолыг 153 орон дэмжиж, санал өгөн баталсан.

Улс орнууд 2012 оны 7 дугаар сард гэрээний агуулгатай холбоотой хэд хэдэн асуудлаар тухайлан гэрээний хамрах хүрээ, зэвсгийн олон улсын шилжүүлэг, экспортоос үүсэж болох эрсдэлийг үнэлэх шалгуур, хэрэгжүүлэх механизм болон зүйл заалтуудыг эцэслэн тохирох хурлыг зохион байгуулсан. Зэвсгийн худалдааны гэрээ хохирол барагдуулахтай холбогдон гарах асуудлуудад цаашид анхаарах хэрэгтэй байна. Ердийн, цэргийн, байлдааны гэх мэт зэр зэвсгийн олон төрөл, мөн бусад холбогдох тоног төхөөрөмжийг Хүний эрхийн олон улсын хууль, олон улсын хүмүүнлэгийн эрх зүй, үндэсний эрүүгийн хууль зэрэг үндэсний болон олон улсын хууль дүрмийг зөрчиж хууль бус, хориотой байдлаар ашигладаг. Зэр зэвсэг ашиглаагүй ч хүчирхийлэл гарсаар байдаг. Хүчирхийлэл хэрхэн үүссэнээс үл хамааран улс орнууд олон улсын эрх зүйг зөрчсөн алдаатай ажиллагааны төлөө тухайн улсын хохирогчдод нөхөн төлбөр олгох үүрэгтэй хэмээх хандлага бат бүрэлдсэн.

Сүүлийн хэдэн арван жил томоохон хүчирхийлэл болоод олон улсын эрх зүй зөрчигдсөний улмаас хохирсон хүмүүсийг хамгаалах, нөхөн төлбөр олгох, шударга ёс тогтоох институци бий болгох, албан болон албан бус механизм бий болгох, хэм хэмжээ боловсруулах талаар нилээдгүй ажил хийгдэж ирсэн билээ. Энэ нь дараахи гэмт хэргийн хохирогчдыг хамгаалахад чиглэсэн. Үүнд:

- Гэмт хэргийн болоод албан тушаалаа урвуулан ашигласны улмаас хохирлыг;
- Хүний эрхийн олон улсын хэм хэмжээг зөрчсөний улмаас хохирсон;
- Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг зөрчсөний улмаас хохирсон;
- Нийлмэл үүнд дайны, хүн төрөлхтөний эсрэг, төрлөөр устгах гэмт хэргийн улмаас хохирсон;
- Террорист үйл ажиллагааны хохирогч;
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч²;

¹Энэ номонд зориулж Эмнести Интернэшнл байгууллага түүвэрлэсэн болно.

²Иймээс, улс орнууд ердийн зэвсгийн олон улсын бүх шилжүүлгийг Олон улсын хуулиар хүлээсэн үүрэг, үндэсний хууль дүрэм, бодлого, тэдгээрийг биелүүлэх үүргийн дагуу хэрэгжүүлнэ. Эмнести Интернэшнл “Зэвсэг шилжүүлэх тухай тогтоолд хүний эрхийн хэм хэмжээг хэрхэн тусгах вэ” (индекс: АСТ 30/008/2008), 2008 он 10 дугаар сарын 1; Олон улсын улаан загалмайн хороо (ICRC), “Зэвсэг шилжүүлэх тухай тогтоол:

Эдгээр механизм болон арга хэмжээний хүрээнд хохирогчийг хамгаалах талаар өргөн хүрээний олон улсын хэм хэмжээ тогтоогджээ. Тус хэм хэмжээнүүдийн дагуу хохирогчдод нөхөн төлбөр олгох талаар улс орнуудад хамааралтай нилээд олон үүргийг заасан байв.

Нөгөө талаасаа зэр зэвсэг, ердийн зэвсэг, зэвсэглэлтэй холбоотой техникүүд үргэлж хууль бусаар ашиглагдаж, үндэсний, олон улсын, үүнд хүний эрхийн талаар олон улсын эрх зүйн хэм хэмжээ, олон улсын хүмүүнлэгийн эрх зүй, үндэсний эрүүгийн эрх зүйг зөрчих нь тохиолддог. Мөн түүнчлэн зэвсэг хэрэглэхгүйгээр хүний эрхийн томоохон зөрчлүүд гаргасаар байна. Хүний эрхийн зөрчил нь ямар ч хэлбэртэй байсан улс бүр тус гэмт хэргийн хохирогчийг хамгаалах талаар үүрэг хүлээдэг байхыг олон улсын хэм хэмжээгээр ногдуулсан билээ.³

1985 оны НҮБ-ын Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаархи хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглал⁴ нь олон улсын хэмжээнд хохирогчдод туслах талаар авсан анхны арга хэмжээ болсон бөгөөд энэ тал дээр томоохон дэвшил авчирсан юм. Нилээд сүүлд буюу 2005 онд Хүний эрхийг ноцтойгоор болон олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн хэм хэмжээг зөрчсөний улмаас хохирсон, хэлмэгдсэн хүмүүс гэм хорыг арилгуулах, нөхөн төлбөр авах эрхийн талаархи үндсэн зарчмын тухай Тунхаглал батлагдсан юм.⁵

Дээр дурьдсан үндсэн зарчмууд нь зөвлөмжийн шинжтэй бөгөөд хүний эрхийн олон улсын эрх зүйн хэм хэмжээ болон олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн дагуу тогтоосон хохирогч хамгаалах талаархи үйл ажиллагаа, журам, механизм, загварыг тодорхойлсон болно.⁶ Олон улсын хүний эрхийн болоод хүмүүнлэгийн эрх зүйг зөрчсөний улмаас хохирсон хохирогчид дараах эрх эдлэнэ.

Үүнд: Нөхөн төлбөр авах, хэргээ шударгаар шийдвэрлүүлэх эрх. Энэ нь холбогдох улс нь эдгээр гэмт хэрэгт буруутай этгээдийг мөрдөн хайх, мөрдөн байцаах болон шийтгэх, олон улсын эрх зүйн дагуу үр дүнтэй аргаар нөхөн төлбөр төлөх үүрэгтэй гэсэн үг юм.

Учирсан хохиролтой дүйцэх хэмжээгээр гэм хороо арилгуулах эрх. Энэ нь;

а. Зөрчигдөхөөс өмнө ямар байсан тэр хэмжээндээ очихуйц сэргээн засах арга хэмжээ

б. Гэмт хэргийн шинж болон хүлээсэн эдийн засгийн хохиролдоо нийцүүлэн нөхөн төлбөр авах;

³Улс орнууд хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох, учирсан гэм хорыг арилгах, багасгах үүрэгтэй бөгөөд уг зөрчлийг хувь хүн үйлдсэн байсан ч олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүйнхээ төлөө Төр хариуцлага хүлээнэ.

⁴Хавсралтад холбогдох эрх зүйн хэмжээний зарим жишээг үзүүлэв.

⁵Ерөнхий ассамблей авч хэлэлцсэнээсээ хойш 15 жилийн дараа буюу 2005 онд Ерөнхий зармыг батлав.

⁶Ерөнхий зарчимд зааснаар “Хохирогч гэж зөрчил үйлдэгч этгээд тогтоогдоогүй, эсхүл түүнтэй төрөл садангийн харилцаатай нь тогтоогдсоноос үл хамааран гэмтэл, хохирол учирсан хүнийг хэлнэ. Хохирол нь шууд болон шууд бус байж болно. Шууд бус хохирогч гэдэгт шууд хохирогчийн гэр бүлийн гишүүд, тэжээн тэтгэгч, түүнчлэн хүнд байдалд орсон хохирогчид тусламж үзүүлэх оролдлого хийж байгаад хохирсон хүмүүс хамаарна.

- в. Сэтгэл зүй, эрүүл мэнд, эрх зүйн болон нийгмийн тусламж авах:
- г. Үнэн зөв мэдээлэл, тоо баримтыг өөрт болон олон нийтэд мэдэгдэх, сураггүй алга болсон хүмүүсийг хайх, ард түмнээсээ уучлал гуйх, гэмт хэрэгт буруутай этгээдэд эрүүгийн болон захиргааны хариуцлага оногдуулах, хохирогчдод хүндэтгэл үзүүлэх, хохирогчдын дурсгалыг тэмдэглэх зэргээр сэтгэл ханамжийн арга хэмжээ авахуулах,
- д. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, дахин ийм зөрчил давтуулахгүй байх чиглэлээр Төрөөс баталгаа авах зэрэг юм.

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙГЭЭР ХАМГААЛАГДСАН ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ

Хэдийгээр олон улсын хэмжээнд хохирогчдыг хамгаалах талаар олон төрлийн механизм тогтсон ч, тэдгээрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх нь ихээнхэн чухал юм. Ингэж байж сая хохирогч хууль ёсны эрхээ бүрэн дүүрэн эдлэж чадах билээ. Эмнести Интернэшнл нь хүний эрхийн талаар олон улсын эрх зүйн хэм хэмжээ болоод олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн хэм хэмжээ ноцтойгоор зөрчсөнөөс болж хохирсон этгээд үндэсний хэмжээнд нөхөн төлбөр олгох, үр дүнтэй аргаар гэм хорыг арилгах асуудлыг нилээд анхаарч, ажиллаж ирсэн. Цаашид ч олон улсын гэрээ хэлэлцээрт тусгагдсан хохирогчийн эрхийг улс орнуудын үндэсний хууль тогтоомжинд тусгуулахаар ажиллах болно.

НҮБ-ын гишүүн улсууд хохирогчийн эрхийг дотоодын хууль тогтоомжиндоо тусгахаар хүлээн зөвшөөрсөн нөхцөлд энэ нь доорхи байдлаар тусгагдвал зохино.

“Оролцогч улс бүр олон улсын эрх зүйн хэм хэмжээ, үүнд хүний эрхийн талаар олон улсын эрх зүйн хэм хэмжээг ноцтой зөрчсөний улмаас хохирогчдод нөхөн төлбөрийг хангалттай олгох, гэм хор арилгах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх арга хэмжээг авах үүрэгтэй.”

Олон улсын эрх зүйд заасны дагуу хохирогч нь дараах эрхийг эдлэнэ.

Үүнд:

- Хэргээ шударгаар шийдвэрлүүлэх;
- Хохиролдоо нийцсэн, үр дүнтэй болон шуурхай байдлаар гэм хороо арилгуулах;
- Зөрчил болон гэм хорыг арилгахтай холбоотой мэдээлэл олж авах.

ХАВСРАЛТ

ХОХИРЛЫГ АРИЛГАХ, НӨХӨН ТӨЛБӨРТЭЙ ХОЛБООТОЙ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

ХҮНИЙ ЭРХИЙН ТАЛААРХИ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭГ ЗӨРЧСӨН ТОХИОЛДОЛД

Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 8-р зүйл

Үндсэн хууль болон бусад хуулиар олгогдсон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай пакт 2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг

Энэхүү Пактад оролцогч улс бүр дараахь үүрэг хүлээнэ:

(а) энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн аливаа хүнийг, ийм зөрчлийг албаны үүргээ гүйцэтгэж байсан этгээд үйлдсэн байсан ч үр нөлөөтэй эрх зүйн хамгаалалтаар хангах;

(б) эрх зүйн хамгаалалт хүссэн аливаа этгээдийн тийм эрхийг эрх бүхий шүүх, захиргаа, хууль тогтоох байгууллага, эсхүл тухайн улсын эрх зүйн тогтолцоонд заасан эрх бүхий бусад байгууллагаас тогтоож байх явдлыг хангах, түүнчлэн шүүхээр хамгаалуулах боломжийг нь бүрдүүлэх;

(в) эрх зүйн хамгаалалт олгож байгаа бол түүнийг эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлэх явдлыг хангах.

26 дугаар зүйл

Хүн бүр хуулийн өмнө тэгш байх бөгөөд аливаа алагчлалгүйгээр хуулиар тэгш хамгаалуулах эрхтэй. Энэ үүднээс аливаа байдлаар алагчилах явдлыг хуулиар хориглох бөгөөд хууль нь арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн байдал буюу бусад байдлаар алагчилахаас бүх хүнийг адил тэгш үр нөлөөтэй хамгаалах баталгааг бүрдүүлэх ёстой.

Арьс үндсээр алагчилах бүх хэлбэрийг хориглох тухай Конвенц

6 дугаар зүйл

Оролцогч улсууд харьяалалдаа байгаа хүн бүрийг энэхүү Конвенцийг зөрчин хүний эрх, үндсэн эрх чөлөөнд халдаж байгаа арьс үндсээр алагчилах аливаа үйлдлээс харьяалах үндэсний шүүх, төрийн бусад байгууллагаар дамжуулан үр нөлөөтэй хамгаалуулах, арга хэмжээ авахуулах, түүнчлэн арьс үндсээр алагчилсны уршгаар үүссэн аливаа хохирлыг шударга бөгөөд зохих ёсоор нөхөн төлүүлэх талаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхээр хангана.

Эрүүдэн шүүх, хэрцгий хүнлэг бусаар хүний нэр төрийг харьцаж шийтгэхийн эсрэг конвенц

14 дүгээр зүйл

1. Оролцогч улс өөрийн эрх зүйн тогтолцоогоороо эрүүдэн шүүгдсэн этгээд хохирлоо арилгуулах, шударга, хангалттай нөхөн төлбөр авах эрх, түүний дотор эрүүл мэндээ бүрэн сэргээхэд шаардлагатай төлбөр гаргуулах эрхийг хүлээн зөвшөөрнө. Эрүүдэн шүүгдсэний улмаас хохирогч нас барвал асран халамжлагч нөхөн төлбөр авах эрхтэй.

2. Энэхүү зүйл нь хохирогч буюу бусад этгээд дотоодын хууль тогтоомжийн дагуу нөхөн төлбөр авах эрхийг хөндөхгүй.

Эмэгтэйчүүдийн эсрэг хүч хэрэглэхээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, тийм үйлдэлд буруутай этгээдийг шийтгэх тухай Америкийн улсуудын хоорондын конвенц

7 дугаар зүйл

Оролцогч улс бүр нь эмэгтэйчүүдийн эсрэг аливаа хүчирхийллийг үл хүлээн зөвшөөрч, тийм хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, шийтгэх талаар арга хэмжээг нэн даруй боломжийн бүх аргаар авах ба үүнтэй холбоотой дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

(Г) хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эд хэргийг шударга бөгөөд үр дүнтэй шүүхээр шийдвэрлэх, тэднийг хамгаалах, цаг тухайд нь хэргийг нь сонсох нөхцлийг бүрдүүлэх

(д) хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд нөхөн төлбөр авах, нөхөн сэргээх хууль зүйн болон захиргааны нөхцлийг бүрдүүлэх.

Африкийн эмэгтэйчүүдийн эрхийн тухай протокол. Африкийн холбоо

4 дүгээр зүйл

Оролцогч улс бүр дараахь асуудлаар үр дүнтэй бөгөөд зохистой арга хэмжээ авах үүрэг хүлээнэ. Үүнд:

(е) Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд нөхөн төлбөр олгох, гэм хор арилгах тогтолцоо бий болгох, үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдүүлэх

Хүүхдийн эрхийн конвенц 39 дүгээр зүйл

Оролцогч улсууд хүүхдийг үл хайхрах, мөлжих, зүй бусаар ашиглах, эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжилсон харьцаа, хандлага, зэвсэгт мөргөлдөөний хохирогч хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд нөхөн сэргээх, нийгмийн амьдралд буцаан оруулахад тус дөхөм болох шаардлагатай бүх арга хэмжээг авна. Ийнхүү нөхөн сэргээх, нийгэмд нэгтгэх үйл явц нь хүүхдийн эрүүл мэнд, нэр төр, үе тэнгийхний хүндэтгэл хангагдсан нөхцөлд хэрэгжих ёстой.

Ял шийтгэлгүй үлдэх байдалтай тэмцэх талаархи НҮБ-ын зарчмууд, 31 дүгээр зарчим

Хүний эрхийн зөрчил нь нэг талаас хохирогч болон түүний залгамжлагчдад эрхээ сэргээлгэх, гэм хороо арилгуулах, нөхөн төлбөр авах, нөгөө талаас улс бүрт түүнд нөхөн төлбөр олгох нөхцлийг бүрдүүлэх үүргийг үүсгэнэ.

ХҮНИЙ ЭРХИЙН БҮС НУТГИЙН КОНВЕНЦИУД

Хүний болон ард түмний эрхийн тухай Африкийн харти, 7 дугаар зүйл

Хүн бүр хэргээ шүүхээр хянан шийдвэрлүүлэх эрхтэй

Хүний эрхийн Америк хоорондын конвенц, 25 дугаар зүйл

Хүн бүр Үндсэн хууль болон энэхүү конвенцид заасан үндсэн эрх нь зөрчигдсөн нөхцөлд шүүх болон цэргийн шүүхээр шийдвэрлүүлэх эрхтэй. Энэхүү эрх мөн тухайн хүний эрхийг зөрчсөн нь гэм буруутай этгээдийн ажил албаны үүрэг байсан эсэхээс үл хамаарна.

Улс бүр дараахь үүрэг хүлээнэ.

- а. Эрх нь зөрчигдсөн хэн бүр нь эрхээ хамгаалах нь тухайн улсын дотоодын хууль тогтоомжид баталгаажсан байх ба эрх бүхий байгууллага нь түүний энэ эрхийг хэрэгжүүлэх;
- б. Шүүхээр эрхээ сэргээлгэх, хамгаалуулах нөхцөл бүрдүүлэх;
- в. Эрх бүхий байгууллага нь зөрчигдсөн эрхийг сэргээх, хамгаалах.

Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенц, 13 дугаар зүйл

Энэхүү конвенцид заагдсан эрх нь зөрчигдсөн хүн бүр үндэсний эрх бүхий байгууллагаар эрхээ хамгаалуулж, сэргээлгэх эрхтэй бөгөөд тухайн гэм буруутай этгээд албан үүргээ гүйцэтгэж байсан эсэхээс үл хамаарна.

Гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох тухай Европын конвенц, 2 дугаар зүйл.

Хэрэв нөхөн төлбөрийг бусад эх үүсвэрээс олгох боломжгүй бол Улс дараахь нөхцөлд нөхөн төлбөрт хувь нэмрээ оруулна . Үүнд:

- а. Олон улсын гэмт хэргийн улмаас эрүүл мэндэд ноцтой хохирол учирсан
- б. Ийм төрлийн гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол түүний асран хамгаалалтанд байсан хүмүүст

Дээрх нөхцөлд гэм буруутай этгээдийн эсрэг эрүүгийн хэрэг үүсгэсэн, шийтгэсэн эсэхээс үл хамаарч нөхөн төлбөрийг олгоно.

ОЛОН УЛСЫН ХҮМҮҮНЛЭГИЙН ЭРХ ЗҮЙ

Хуурай газар дээрх дайны хууль болон журмын талаар Гаагийн конвенц, 1907 оны 10 дугаар сарын 18 , 4 дүгээр Конвенц, 3 дугаар зүйл

Энэхүү гэрээний дагуу заасан журмыг зөрчсөн тал нь шаардлагатай нөхцөлд нөхөн төлбөр олгох үүрэг хүлээнэ. Тухайн улс нь түүний зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд багтаж байгаа хүн бүрийн үйлдлийн төлөө хариуцлага хүлээнэ.

1949 оны 8 дугаар сарын 12-нд өдрийн Женевийн Конвенцийн Олон улсын зэвсэгт мөргөлдөөнд энгийн иргэдийг хамгаалах тухай 1977 оны 6 дугаар сарын 8-ний өдрийн нэмэлт протокол

(1 дүгээр протокол) –ын 91 дүгээр зүйлд “Энэхүү конвенц болон түүний нэмэлт протоколыг зөрчсөн тал нь шаардлагатай нөхцөлд нөхөн төлбөр төлөх үүрэгтэй

гэжээ. Тухайн улс нь түүний зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд багтаж байгаа хүн бүрийн үйлдлийн төлөө хариуцлага хүлээнэ” гэжээ.

Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм, 75 дугаар зүйл

Шүүх нь гэм хорыг арилгах, нөхөн төлбөр, сэргээх нөхөн төлбөр (реституц) ногдуулах, цагаатгах зэргээр холбогдох хохирлыг нөхөн төлөхтэй холбогдсон зарчмыг тодорхойлно. Энэ үндсэн дээр шүүх гаргасан хүсэлт буюу онцгой тохиолдолд өөрийн санаачлагаар шийдвэртээ хохирогч буюу түүний хувьд учирсан аливаа хохирол, алдагдал буюу гэм хорын хүрээ болон хэмжээг тодорхойлж болох бөгөөд өөрийн үйл ажиллагаа явуулж байгаа зарчмын талаар мэдээлнэ. Шүүх хохирогчдын хувьд эрхийг нь сэргээх, нөхөн төлбөр ногдуулах болон цагаатгах зэрэг хохирлыг зохих хэлбэрээр нөхөн төлүүлэх талаар ял шийтгүүлэгчид шууд хамаарах тогтоол гаргаж болно.

Шүүхээс шүүн шийдвэрлэх хэрэгт хамаарах гэмт хэргийн улмаас хохирогч болон тийм хохирогчдын гэр бүлийнхний тусын тулд оролцогч улсуудын Ассамблейн шийдвэрээр Итгэмжлэгдсэн сан байгуулж болно гэж 79 дүгээр зүйлд заажээ.

ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ

НҮБ-ын мансууруулах бодис болон гэмт хэргийн асуудлаархи хороо (UNODC) нь гэмт хэргийн хохирогчдын талаар нилээд их ажил хийсэн. Тус хорооны санаачлага, иргэний нийгмийн дэмжлэгтэйгээр хохирогчдын асуудлыг нилээд анхаарч үүний үр дүнд Гэмт хэргийн болон эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас хохирогчдын хувьд шударга ёсыг тогтоох ба дэмжих талаар НҮБ-ын Конвенцийн төслийг боловсруулсан билээ. Тус гэрээний төсөлд Хохирогчдын тухай Тунхаглалд тодорхойлсончилон хохирогчдын эрхийг зааснаас гадна дараах зүйлийг мөн агуулсан.

- Хэргээ шударга шүхээр шийдвэрлүүлэх ба зүй ёсоор харьцахыг шаардах эрх (Үүнд хохирогч, гэрч болон шинжээч, түүнчлэн мэдээллийг хамгаалах)
- Хохирогчдод засгийн газрын, сайн дурын болон нийгмийн ажлын хүрээнд эд хөрөнгийн, эмнэлгийн, сэтгэл санааны нийгмийн тусламж үзүүлэх
- Эрхийг нь сэргээх, гэм хорыг арилгах
- Шударга ёсыг сэргээн тогтоох
- Нөхөн төлбөр

НҮБ-ын Гэмт хэргийн болон эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас хохирогчдын эрхийн тухай Үндсэн зарчмын НҮБ-ын Тунхаглал, 4 дүгээр зүйл

Хохирогчтой зүй ёсоор болон нэр хүндийг нь хүндэтгэх харьцах ёстой. Тэдгээр нь үндэсний хууль тогтоомжид заасны дагуу шударга ёсыг хангуулах, эрхээ сэргээлгэх болон хохиролоо нөхөн төлөхөд хангалттай нөхөн төлбөр авах эрхтэй гэжээ.

НИЙЛМЭЛ ГЭМТ ХЭРЭГ

Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрмийг баталснаар анх удаа олон улсын эрүүгийн шүүх гэмт хэрэгт буруутай этгээдэд хохирогчдод учруулсан гэм хорыг арилгах, тухайлан нөхөн төлбөр, сэргээн засах хариуцлагыг ногдуулах эрхтэй болсон.

Ромын дүрмийн хүрээнд тодорхой төрлийн гэм хэргийн (Төрлөөр устгах, дайны, хүн төрөлхтөний эсрэг, түрэмгийллийн гэмт хэрэг) хохирогчдыг хамгаалах хоёр тусдаа тогтолцоог бий болгосон юм. Эхнийх нь Ромын Дүрмийн 75 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шүүх нь сэргээх нөхөн төлбөр (реституц) үүргийг ногдуулах болон цагаатгах зэрэг хохирогчид буюу хохирогчдын хувьд холбогдох хохирлыг нөхөн төлөхтэй холбогдсон зарчмыг тодорхойлно гэжээ. Энэ үндсэн дээр шүүх гаргасан хүсэлт буюу онцгой тохиолдолд өөрийн санаачлагаар шийдвэртээ хохирогч буюу түүний хувьд учирсан аливаа хохирол, алдагдал буюу гэм хорын хүрээ болон хэмжээг тодорхойлж болох бөгөөд өөрийн үйл ажиллагаа явуулж байгаа зарчмын талаар мэдээлнэ.

Хоёрдахь нөхцөл нь Олон улсын эрүүгийн шүүхээр авч хэлэлцэж буй аливаа хэргийн хохирогчтой шууд холбоогүй. Олон улсын эрүүгийн шүүхийн дэргэд тусдаа бие даасан Хохирогчдод санг байгуулсан бөгөөд зорилго нь Шүүхэд харьяалагддаг гэмт хэргийн хохирогч болон тэдний гэр бүлийн гишүүдэд зориулж өөрийн сангийн мөнгийн зарцуулах юм. Энэхүү хоёр дахь механизм нь тодорхой нөхцөл байдалд үндэслэн хохирогчдод туслах бөгөөд ОУЭШ-ийн Дүрмийн 75 дугаар зүйлд заасан гэмт хэргийг авч хэлэлцэх үйл ажиллагаанаас гадна хохирогчдыг хамгаалах нэмэлт механизм билээ. Учир нь ОУЭШ нь өөрт харьяалагдах гэмт хэрэгт буруутай этгээдийг л шүүх хязгаарлагдмал эрхтэй байдаг. Тус сан нь Засгийн газар, олон улсын байгууллага, хувь хүмүүсээс өгсөн санхүүгийн хандивыг ОУЭШ-ээр авч хэлэлцсэн хэрэгтэй холбоогүйгээр 2010 оны байдлаар Конго болон Уганда улсад хүн төрөлхтөний эсрэг, дайны гэмт хэрэгт хохирогчдод туслах зорилго бүхий 31 төслийг хэрэгжүүлсэн байна.

Олон улсын эрх зүйн ассоциаци, Зэвсэгт мөргөлдөөний явцад хохирогчдод туслах талаар олон улсын эрх зүйн зарчмын тухай тунхаглалын төсөл, 6 дугаар зүйл;

Зэвсэгт мөргөлдөөний хохирогч гэм хорыг арилгуулах, сэргээлгэх нөхөн төлбөр авах эрхтэй бөгөөд үүргийг хариуцагч талууд хүлээнэ.

ТЕРРОРИСТ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХОХИРОГЧИД

НҮБ-ын терроризмын эсрэг дэлхийн стратеги- 2005 он, Хэсэг 1, дэд хэсэг -8

“Улс бүр Терроризмын гэмт хэргээс хохирсон хохирогч, тэдний гэр бүлд туслах арга хэмжээ авах төдийгүй, эргээд тэднийг хэвийн байдалд оруулах талаар үндэсний тогтолцоо бүрдүүлэх нь зүйтэй. Энэ хүрээнд НҮБ-д хандаж ийм үндэсний механизмыг бий болгох талаар туслалцаа авч болно. Мөн түүнчлэн хохирогчдыг дэмжих дэлхийн нэгдсэн дуу хоолой, хамтын ажиллагааг бий болгох, терроризм, түүний үр дүнгийн талаар дэлхийн кампанит ажлыг зохион байгуулахад иргэний нийгмийн төлөөлөгчдийг оролцуулан ажиллаж байна.”

НҮБ-ын мансууруулах бодис болон гэмт хэргийн асуудлаарх хороо нь гэмт хэрэг болон террорист үйл ажиллагааны хохирогчдыг анхааран ажилладаг. Тухайлбал тус хороо нь НҮБ-ын терроризмын эсрэг тусгай үүрэг бүхий байгууллагатай хамтран терроризмын гэмт хэргээс хохирогчдод үндэсний хэмжээнд хэрхэн туслаж байгаа талаар судалгаа хийдэг. Энэхүү судалгаа НҮБ-ын мансууруулах бодис болон гэмт хэргийн асуудлаарх хороо нь техникийн туслалцааны арга замыг тодорхойлж, НҮБ-ын терроризмын эсрэг тусгай үүрэг бүхий байгууллагын хэвлэл мэдээллийн сургалтын хөтөлбөр, хохирогчдод үзүүлэх санхүүгийн тусламжийн хэмжээний талаар нэмэлт мэдээллийн үндэс болсон юм.

ХҮН ХУДАЛДАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИД

2000 оны Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн тухай Конвенц ба хүний наймааны тухай түүний нэмэлт протокол-д хохирогчидтой холбоотой дараах эрх зүйн хэм хэмжээ агуулагддаг.

6.2 дугаар зүйл

Оролцогч улс бүр өөрийн үндэсний хууль болон захиргааны тогтолцооны дагуу хүн худалдах гэмт хэргийн хохирогч бүрт дараахь нөхцлийг бүрдүүлэх үүрэгтэй. Үүнд:

А. Шүүхийн болон захиргааны үйл ажиллагааны талаар мэдээлэл олж авах

Б. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангах

3. Хүн худалдах гэмт хэргийн хохирогч бүрт шаардлагатай бол төрийн бус байгууллага болон бусад холбогдох байгууллага, иргэний нийгмийн төлөөлөгчидтэй хамтран бие сэтгэл зүйн хувьд сэргээн засах, нийгмийн тусламж үзүүлэх талаар арга хэмжээг хэрэгжүүлэх нь оролцогч улс бүрийн үүрэг гэжээ.

ЗЭВСГИЙН ТАЛААРХИ ТУСГАЙ ГЭРЭЭ

Олон улсын гэрээний дагуу хэрэглэхийг хориглосон зэвсгийн, эсхүл хориглоогүй боловч иргэдэд ноцтой хохирол учруулах шинж чанартай зэвсгийн улмаас гэмтсэн, хохирсон хохирогчдод эмнэлгийн, нөхөн сэргээлтийн, сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх шаардлагын талаар зэвсгийн талаарх сүүлийн үеийн гэрээнүүдэд өргөнөөр тусгах болсон.

Бутардаг зэвсгийн конвенц

Оролцогч улс бүр цацардаг хошууны улмаас өөрийн харьяат хохирогчид олон улсын хүмүүнлэгийн эрх зүй, хүний эрхийн хэм хэмжээний дагуу нас, хүйсэнд нь тохирсон эмнэлгийн, нөхөн сэргээх, сэтгэл зүйн туслалцаа үзүүлэхийн зэрэгцээ тэдэнд нийгэм, эдийн засгийн хувьд амьдрах нөхцлийг бүрдүүлэх үүрэгтэй. Улс бүр энэ зэвсгийн улмаас хохирсон хохирогчдын тоо мэдээллийг цуглуулах ажлыг зохион байгуулна.

Газрын минийн тухай конвенц

б.3-р зүйл

Оролцогч улс бүр нь газрын минийн хохирогчдод тусламж үзүүлэх, нөхөн сэргээх, нийгэм эдийн засгийн хувьд амьдрах нөхцлийг бүрдүүлэх үүрэгтэй. Энэхүү тусламжийг НҮБ-ын тогтолцоо, холбогдох олон улсын, бүс нутгийн болон үндэсний байгууллага, Олон улсын улаан загалмайн хороо, Үндэсний улаан загалмай, Хавирган сарын хороо, Төрийн бус байгууллагаар дамжуулан өгч болно.

Дайны тэсрэх бодисын талаар Протокол, 1980 оны Конвенцийн 5 дугаар протокол 2003 оны 11 дүгээр сарын 28, 8.2-р зүйл

Оролцогч улс бүр дайны үеэр тэсрэх бодис хэрэглэсний улмаас хохирогчдод тусламж үзүүлэх, гэм хорыг арилгах, сэргээх нөхөн төлбөр олгох, нийгэм, эдийн засгийн хувьд амьдрах нөхцөл бүрдүүлэх үүрэгтэй. Энэхүү тусламжийг НҮБ-ын тогтолцоо, холбогдох олон улсын, бүс нутгийн болон үндэсний байгууллага, Олон улсын улаан загалмайн хороо, үндэсний улаан загалмай, хавирган сарын хороо, төрийн бус байгууллагаар дамжуулан өгч болно.

Эмнести Интернэшнл нь 150 гаруй улс орон, газар нутагт 3 сая хүнийг хамарсан хүний эрхийн хамгаалагчдын даян дэлхийн хөдөлгөөн юм. "Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал" бусад олон улсын хүний эрхийн жишиг хэмжээнд заасан хүний эрх, эрх чөлөөг энэ дэлхийн хүн бүрт бүрэн эдлүүлэхэд оршино. Бид аливаа засгийн газар, улс төрийн үзэл бодол, эдийн засаг, шашны үзлээс ангид гишүүд болон олон нийтийн хандиваар санхүүждэг билээ.

**ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ**



Хаяг: Сүхбаатар дүүрэг,
6-р хороо,
Бага тойруу - 44, 1 давхарт
Утас: факс: 976-11-324705
Цахим шуудан: amncs@maginet.mn
www.amnesty.mn



Шуудангийн хаяг: Монгол улс,
Улаанбаатар хот - 210648
Шуудангийн хайрцаг: 180

www.amnesty.org